



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/43

Аргатай

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно" заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Аргатай 3-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй "Болор жонш" ХХК-ний дур мэдэн зөвшөөрөлгүй газарт цооног өрөмдөж худаг гарган 2021 оноос хойш ашиглан ирсэн тул дээрх хуулийн дагуу зөрчлийг таслан зогсоох хүртэл ус ашиглахгүй байхыг Болоржонш ХХК-нд үүрэг болгосугай.
2. Зөрчлийг арилгах хүртэл ус, газар ашиглахгүй байхыг Болоржонш ХХК-ний захирал (С.Сэргэлэн)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллахыг Газрын даамал (Т.Шуухааз), Аргатай 3 дугаар багийн засаг дарга (Б.Пүрэвбаяр), Байгаль орчны мэргэжилтэн (Х.Сарангэрэл) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ГЭЛЭГ  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ЗОЛЗАЯА

БОЛОРЖОНШ ХХК-НИЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ГАЗАРТ ГАРГАСАН

ХУДГИЙГ ЛАЦАДСАН АКТ


2023.08.02

Аргатай

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/43 тоот “Зөрчил арилгуулах тухай” захирамжийн дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Эрдэнэбат, Сумын засаг даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Золзаяа, Аргатай 3 дугаар багийн засаг дарга Б.Пүрэвбаяр, Байгаль орчны мэргэжилтэн Х.Сарангэрэл, Газрын даамал Т.Шуухааз, Архив, бичиг хэргийн эрхлэгч М.Цэрэнбадам нар Болоржонш ХХК-ний зөвшөөрөлгүй газарт цооног өрөмдөж худаг гаргасан зөрчилтэй тул зөрчлийг таслан зогсоох хүртэл ус ашиглахгүй байхыг үүрэг болгож, худгийн тогны 2 сейфийг 4 тоот лацаар 18:37 минутад очин лацдав.

АКТ ҮЙЛДСЭН:

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЗОЛЗАЯА

БАЙЛЦСАН:

|                                     |  |              |
|-------------------------------------|--|--------------|
| ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА |  | Д.ЭРДЭНЭБАТ  |
| АРГАТАЙ 3 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА |  | Б.ПҮРЭВБАЯР  |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН           |  | Х.САРАНГЭРЭЛ |
| ГАЗРЫН ДААМАЛ                       |  | Т.ШУУХААЗ    |
| АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ        |  | М.ЦЭРЭНБАДАМ |
| БОЛОРЖОНШ ХХК-НИЙ ОРЧУУЛАГЧ         |  | СОЁМБО       |

АКТ ХҮЛЭЭН АВСАН:

БОЛОРЖОНШ ХХК-НИЙ ҮЙЛДВЭРИЙН МЕНЕЖЕР

Ч.ДАЛАЙХҮҮ